

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Бугат сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГAA-2026/008/HA-CTA-TT3

Цахим хуудас: www.audit.mn

Алтай хот

2026 он

Дарга, Тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа

Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг

Утас: 99175677 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Цэрэнханд

Утас: 99086371 Цахим хаяг: Tserenkhandd@audit.gov.mn

Аудитор: Н.Гэрэлмаа

Утас: 99782918 Цахим хаяг: Gerelmaan@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

Хоёр. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	3
Гурав. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	7
Дөрөв. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	10
Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл.....	13

Товчилсон үгийн жагсаалт

ААТҮГ	Аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ХХС	Хоршоо хөгжүүлэх сан
БХНСС	Байгаль хамгаалах нөхөн сэргээх сан
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар



**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82091
Утас: (976) 70 48 34 13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn

2026. 03.24 № 140

танай _____ -ны № _____ -т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Бугат сумын Засаг даргын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн доор зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй болно. Үүнд:

- Ан амьтны нөөц ашигласны төлбөр 18.1 сая төгрөгөөр, малын тоо толгойд ногдуулах албан татвар 5.3 сая төгрөгөөр, улсын тэмдэгтийн хураамж 0.4 сая төгрөгөөр, торгуулийн орлого 0.3 сая төгрөгөөр тасарсан,
- Сумын орон нутгийн төсвөөс Засаг даргын Тамгын газарт 16.7 сая төгрөгийн, цэцэрлэгт 0.5 сая төгрөгийн, соёлын төвд 0.6 сая төгрөгийн тогтмол зардлын санхүүжилтийг тус тус дутуу олгосон,
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчин Засаг даргын нөөц хөрөнгөнөөс шагнал урамшуулалд 1.4 сая төгрөгийг үр ашиггүй зарцуулсан,

822511000457

- Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн харьяа нэгж, байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар залруулагдаагүй 22.8 сая төгрөгийн зөрчил илэрсэн.

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.6, 16.5.7, 41 дүгээр зүйлийн 41.1, 41.2.5, 41.2.7 дахь заалтуудтай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Баруун бүсийн сумдын тэмээчдийн уулзалт, зөвлөгөөнийг Алаг нуурын говьд зохион байгуулсан байна. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 8 айлын орон сууц барих ажил дууссан, улсын комисс хүлээн аваагүй байна.

Сумын орон нутгийн төсвийн орлогыг 582.6 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 590.2 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, 16.4 сая төгрөгөөр буюу 101.0 хувьтай биелүүлсэн байна.

Тайлант онд аймгийн төсвөөс 813.6 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгохоор төлөвлөснийг бүрэн авсан байна.

Аудитын гол асуудал

Засаг даргын нөөц хөрөнгийг зарцуулах журмаар шагнал урамшуулал, нэг удаагийн буцалтгүй тусламж, дэмжлэг олгох бүрэн эрхийг Засаг даргад олгосон боловч Төрийн хэмнэлтийн тухай хуулиар дээрх арга хэмжээний зардлыг зарцуулахыг хориглосон байна.

Орон нутгийн хөгжлийн сан болон бусад эх үүсвэрээс 389.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авч бүртгэсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Тайлант онд 1 хөтөлбөр, 4 зорилт, 86 арга хэмжээ хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас 76.1 хувьтай үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Б.ГҮНЖИДМАА

Хоёр. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан (мянган төгрөг)

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	939,082.2	1,137,425.7
2	МӨНГӨН ХӨРӨНГӨ	602,011.9	689,698.8
3	АВЛАГА	86,883.1	109,950.6
4	БАРАА МАТЕРИАЛ	160,834.9	157,810.2
5	НӨӨЦИЙН БАРАА	50,360.3	36,850.2
6	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	38,992.0	143,115.9
7	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,640,543.0	1,811,378.7
8	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,640,543.0	1,811,378.7
9	Биет хөрөнгө	1,543,815.0	1,686,810.7
10	Биет бус хөрөнгө	96,728.0	124,568.0
11	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2	2,579,625.2	2,948,804.4
12	НИЙТ ӨР ТӨЛБӨР	23,154.4	151,743.1
13	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	23,154.4	151,743.1
14	Өглөг	23,154.4	151,743.1
15	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,556,470.8	2,797,061.2
16	Засгийн газрын хувь оролцоо	2,556,470.8	2,797,061.2
17	Засгийн газрын оруулсан капитал	604,481.9	604,481.9
18	Хуримтлагдсан үр дүн	1,729,174.0	1,969,764.5
19	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	222,814.9	222,814.9
20	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5	2,579,625.2	2,948,804.4

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан (мянган төгрөг)

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	2,361,606.9	2,219,977.7
2	ТАТВАРЫН ОРЛОГО	560,353.7	581,777.7
3	Орлогын албан татвар	526,858.4	497,988.4
4	Хувь хүний орлогын албан татвар	546,923.7	541,605.3
5	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(20,065.3)	(43,616.9)
6	Хөрөнгийн албан татвар	17,119.5	46,816.0
7	Бусад татвар, төлбөр, хураамж	16,375.8	36,973.3
8	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	555,452.2	1,638,200.0
9	Тусламжийн орлого	-	822,393.2
10	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,245,801.0	-
11	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,736,603.4	1,792,158.0
12	УРСГАЛ ЗАРДАЛ	1,736,603.4	1,792,158.0
13	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,694,482.8	1,773,830.0
14	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	752,223.4	808,288.8
15	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	91,353.0	127,775.8
16	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	506,330.9	531,974.9
17	Хангамж, бараа материалын зардал	51,870.4	32,834.8
18	Эд хогшил, урсгал засварын зардал	7,024.2	2,685.7
19	Томилолт, зочны зардал	6,515.0	3,874.0
20	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	14,083.7	16,393.2
21	Бараа үйлчилгээний бусад зардал	265,082.2	250,002.8

22	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	42,120.6	18,328.0
23	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (Ш)=(1)-(П)	625,003.5	427,819.7
24	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	247,994.7	187,229.3
25	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (УИ)=(1У)-(У)	(247,994.7)	(187,229.3)
26	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (Y1)=(111)+(ҮП)	377,008.8	240,590.5

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (мянган төгрөг)

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,179,462.0	2,179,462.0
2	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,179,462.0	2,179,462.0
3	Тайлант үеийн үр дүн	377,008.8	377,008.8
4	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,556,470.8	2,556,470.8
5	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	2,556,470.8	2,556,470.8
6	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,556,470.8	2,556,470.8
7	Тайлант үеийн үр дүн	240,590.5	240,590.5
8	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,797,061.2	2,797,061.2

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан (мянган төгрөг)

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	1,860,403.7	1,871,989.0
2	ТАТВАРЫН ОРЛОГО	560,353.7	587,450.2
3	Орлогын албан татвар	526,858.4	503,660.9
4	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(20,065.3)	(43,616.9)
5	Хөрөнгийн албан татвар	17,119.5	46,816.0
6	Бусад татвар, төлбөр, хураамж	16,375.8	36,973.3
7	Бусад нийтлэг төлбөр, хураамж	5,468.1	3,221.6
8	Газрын төлбөр	10,730.4	14,881.7
9	Байгалийн нөөц ашигласны төлбөр	177.3	18,869.9
10	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	54,249.0	1,284,538.8
11	Нийтлэг татварын бус орлого	54,249.0	64,202.0
12	Тусламжийн орлого	-	822,393.2
13	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	-	397,943.7
14	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,245,801.0	-
15	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,567,548.2	1,458,809.7
16	УРСГАЛ ЗАРДАЛ	1,567,548.2	1,458,809.7
17	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,526,927.7	1,452,153.7
18	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	743,444.0	817,068.2
19	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	91,353.0	127,775.8
20	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	506,330.9	426,514.2
21	Хангамж, бараа материалын зардал	47,038.5	22,932.5
22	Эд хогшил, урсгал засварын зардал	8,138.9	1,945.7

23	Томилолт, зочны зардал	6,515.0	3,874.0
24	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	60,888.7	5,572.8
25	Бараа үйлчилгээний бусад зардал	63,218.6	46,470.6
26	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	40,620.6	6,656.0
27	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (111)=(1)-(11)	292,855.5	413,179.3
28	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	327,873.2	275,492.4
29	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	327,873.2	275,492.4
30	Дотоод эх үүсвэрээр	327,873.2	275,492.4
31	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (Y1)=(1Y)-(Y)	(327,873.2)	(275,492.4)
32	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	-	50,000.0
33	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-	(50,000.0)
34	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (Y111)=(111)+(Y1)+(Y11)	(35,017.7)	87,686.9
35	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	637,029.6	602,011.9
36	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	602,011.9	689,698.8

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан (мянган төгрөг)

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

Код	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	2,287,340.3	1,837,069.5	450,270.8	80.3
11	Татварын орлого	579,497.4	587,450.2	(7,952.8)	101.4
110	Орлогын албан татвар	481,841.5	503,660.9	(21,819.4)	104.5
1100	Хувь хүний орлогын албан татвар	525,458.4	547,277.8	(21,819.4)	104.2
110001	Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого	397,642.5	404,776.8	(7,134.3)	101.8
110002	Үйл ажиллагааны орлого	17,146.4	24,261.9	(7,115.5)	141.5
110003	Хөрөнгийн орлого	70,621.0	75,487.3	(4,866.3)	106.9
110008	Шууд бус орлого	40,048.5	42,751.8	(2,703.3)	106.8
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(43,616.9)	(43,616.9)	-	100.0
110101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(43,616.9)	(43,616.9)	-	100.0
113	Хөрөнгийн албан татвар	49,108.0	46,816.0	2,292.0	95.3
113001	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	3,667.0	5,391.3	(1,724.3)	147.0
113002	Бууны албан татвар	2,730.0	4,024.0	(1,294.0)	147.4
113004	Малд ногдуулах албан татвар	42,711.0	37,400.7	5,310.3	87.6
118	Бусад татвар, төлбөр, хураамж	48,547.9	36,973.3	11,574.6	76.2
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	3,087.9	3,221.6	(133.7)	104.3
118001	Улсын тэмдэгтийн хураамж	3,087.9	2,721.6	366.3	88.1
118009	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	-	500.0	(500.0)	
1181	Газрын төлбөр	8,500.0	14,881.7	(6,381.7)	175.1
118101	Газрын төлбөр	8,500.0	14,881.7	(6,381.7)	175.1
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	36,960.0	18,869.9	18,090.1	51.1
118202	Ан амьтны нөөц ашигласны төлбөр	36,960.0	18,869.9	18,090.1	51.1
12	Татварын бус орлого	1,707,842.9	1,249,619.3	458,223.6	73.2
120	Нийтлэг татварын бус орлого	112,694.3	38,117.9	74,576.4	33.8
120003	Торгуулийн орлого	3,053.2	2,741.5	311.7	89.8
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/	80,000.0	31,389.7	48,610.3	39.2

Бугат сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

120010	Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/	29,641.1	370.8	29,270.3	1.3
120009	Бусад орлого	-	3,615.9	(3,615.9)	
122	Тусламжийн орлого	813,557.8	813,557.8	-	100.0
122003	Аймаг нийслэлээс авсан татаас	813,557.8	813,557.8	-	100.0
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	781,590.8	397,943.7	383,647.1	50.9
123002	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	401,963.3	397,943.7	4,019.6	99.0
	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	379,627.5	-	-	-
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,287,340.3	1,752,657.6	534,682.7	76.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,519,991.2	1,427,165.3	92,825.9	93.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,501,163.2	1,420,509.3	80,653.9	94.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	849,682.9	817,068.2	32,614.7	96.2
210101	Үндсэн цалин	384,508.8	382,513.5	1,995.3	99.5
210102	Нэмэгдэл	371,675.1	362,548.9	9,126.2	97.5
210103	Унаа хоолны хөнгөлөлт	28,656.0	27,424.4	1,231.6	95.7
210104	Урамшуулал	64,843.0	44,581.4	20,261.6	68.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	135,720.2	127,775.8	7,944.4	94.1
210201	Тэтгэврийн даатгал	104,278.8	101,422.9	2,855.9	97.3
210202	Тэтгэмжийн даатгал	7,860.3	6,588.2	1,272.1	83.8
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,930.2	3,451.8	478.4	87.8
210204	Ажилгүйдлийн даатгал	3,930.2	3,137.2	793.0	79.8
210205	Эрүүл мэндийн даатгал	15,720.7	13,175.7	2,545.0	83.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	434,464.2	426,514.2	7,950.0	98.2
210301	Гэрэл, цахилгаан	37,745.5	30,168.0	7,577.5	79.9
210302	Түлш, халаалт	396,346.2	396,346.2	-	100.0
210303	Цэвэр, бохир ус	372.5	-	372.5	-
2104	Хангамж, бараа материалын зардал	29,119.0	21,911.9	7,207.2	75.2
210401	Бичиг хэрэг	2,029.0	1,240.0	789.0	61.1
210402	Тээвэр, шатахуун	21,790.0	15,526.1	6,264.0	71.3
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,200.0	1,053.8	146.2	87.8
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,500.0	1,492.0	8.0	99.5
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,600.0	2,600.0	-	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,500.0	1,945.7	554.3	77.8
210604	Урсгал засвар	2,500.0	1,945.7	554.3	77.8
2107	Томилолт, зочны зардал	6,280.0	3,874.0	2,406.0	61.7
210702	Дотоод албан томилолт	6,280.0	3,874.0	2,406.0	61.7
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,390.0	2,652.8	1,737.2	60.4
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,200.0	919.2	280.8	76.6
210803	Даатгалын үйлчилгээ	200.0	-	200.0	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	400.0	207.6	192.4	51.9
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	150.0	22.0	128.0	14.7
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,440.0	935.0	505.0	64.9
210807	Газрын төлбөр	1,000.0	569.0	431.0	56.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	39,006.9	18,766.8	20,240.2	48.1
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	38,006.9	17,993.8	20,013.1	47.3
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,000.0	773.0	227.1	77.3
2132	Бусад урсгал шилжүүлэг	18,828.0	6,656.0	12,172.0	35.4
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	17,328.0	6,156.0	11,172.0	35.5

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,500.0	500.0	1,000.0	33.3
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	687,349.1	275,492.4	411,856.7	40.1
223001	Бусад хөрөнгө	687,349.1	275,492.4	411,856.7	40.1
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	80,000.0	50,000.0	30,000.0	62.5
230001	Эргэж төлөгдөх зээл	80,000.0	50,000.0	30,000.0	62.5
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	602,011.9	587,439.5		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	689,698.8	671,851.4		

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан (мянган төгрөг)

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

Код	Дансны нэр, төрөл	Дүн
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	32,835.4
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	32,835.4
122	Тусламжийн орлого	32,835.4
1221	Хандив тусламж /дотоод/	32,835.4
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	32,835.4
350014	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	29,220.4
350015	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,615.0
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	29,219.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	29,219.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	29,219.5
2104	Хангамж, бараа материалын зардал	1,020.7
210402	Тээвэр, шатахуун	870.7
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	150.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,920.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,920.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	25,278.8
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	25,278.8
4	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,615.9

Гурав. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

3.1 Аудитаар нийт 241.4 сая төгрөгийн 2 алдаа илрүүлснийг аудитын явцад залруулсан байна.

Залруулсан алдаа:

- **Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:** Санхүүгийн тайланд ерөнхий боловсролын сургуулийн 53.0 сая төгрөг, цэцэрлэгийн 9.6 сая төгрөгийн, нийт 62.6 сая төгрөгийн өр төлбөрийг дутуу тайлагнасныг залруулсан.
- **Мэдээллийг орхигдуулсантай холбоотой:** Шилэн дансны цахим хуудсанд мэдээлбэл зохих 4,303.0 сая төгрөгийн 132 мэдээллээс бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийн 178.8 сая төгрөгийн 11 мэдээллийг тус тус мэдээлээгүйг нөхөн байршууллаа.

3.1.1 Харьяа байгууллагууд

Бугат сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 2 төсвийн байгууллага, 3 тусгай сан, 5 байгууллагын (Сургууль, Соёлын төв, Цэцэрлэг, Эрүүл мэндийн төв, Бага сургууль) тогтмол зардал нэгтгэсэн байна.

Аудитаар ЗДТГ-ын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийж “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн ба сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, ХХС, Байгаль хамгаалах нөхөн сэргээх сан, Орон нутгийн хөгжлийн сан, Сургууль, Соёлын төв, Цэцэрлэг, Эрүүл мэндийн төв, бага сургуулийн тогтмол зардлыг аудитын түүвэрт хамруулсан.

3.1.2 Түүвэрт хамрагдсан иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Хоршоо хөгжүүлэх сан, Байгаль хамгаалах нөхөн сэргээх сан, Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчил:

Аудитаар нягтлан бодох бүртгэл, тайлагналыг 49.3 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан 6 алдааг залруулж, 2.9 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 17.9 сая төгрөгийн 3 зөвлөмж, зөрчлийг арилгах 2 албан шаардлага хүргүүлсэн байна.

3.1.3 Засаг даргын Тамгын газрын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчил:

Аудитаар нягтлан бодох бүртгэл, тайлагналыг 363.9 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан, мэдээллийг тусгахгүй орхигдуулсан нийт 3 алдааг залруулж, 2.0 сая төгрөгийн 3 зөвлөмжийг хүргүүлсэн байна.

3.2 Төсвийн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын илрүүлэлт:

Аудитаар залруулагдаагүй нийт 43.2 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь тогтоосон материаллаг байдлын түвшнээс их бөгөөд харьяа байгууллагуудын материаллаг зөрчил 22.8 сая төгрөг байгаа тул шинж чанарыг харгалзан үзэж “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 66.0 сая төгрөгийн 5 зөрчил илрүүлснээс зөрчлийг арилгах 1 албан шаардлага, 3 зөвлөмжийг хүргүүлж байна.

3.3 Албан шаардлага

Нэг. Төсөвт байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 436.0 сая төгрөгийн зөрчил илэрснээс аудитын явцад 413.2 сая төгрөгийн алдааг залруулсан ба 2.9 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, зөрчлийг цаашид давтан гаргахгүй байх 2 албан шаардлага, 19.9 сая төгрөгийн 6 зөвлөмжийг холбогдох байгууллагад хүргүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах"; 14.2.5-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах"; 16 дугаар зүйлийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", 16.5.6-т "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх"; гэж заасныг зөрчсөн, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд тавих санхүүгийн дотоод хяналтыг сайжруулж, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

3.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Батлагдсан төсөв, төсвийн гүйцэтгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Нэг. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчин засаг даргын нөөц хөрөнгөнөөс урьдчилан сэргийлэх үзлэг хийхэд хоол хүнсэнд 1.1 сая төгрөг, шагнал урамшуулалд 0.3 сая төгрөгийг тус тус зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4-т "хуулиар зөвшөөрөөгүй бусад" гэж заасантай нийцэхгүй, хуваарилалт, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Засаг даргын нөөц хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж байх.

Хоёр. Сумын орон нутгийн төсвөөс Засаг даргын Тамгын газарт 16.7 сая төгрөгийн, цэцэрлэгт 0.5 сая төгрөгийн, соёлын төвд 0.6 сая төгрөгийн тогтмол зардлын санхүүжилтийг тус тус дутуу олгосон байгаа нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.2-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөрийн санхүүжилтийг бодитой тодорхойлох"; 14.2.5-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах"; 41 дүгээр зүйлийн 41.1-т "Батлагдсан төсвийг хэрэгжүүлэх нарийвчилсан хуваарь, төсвийн дэлгэрэнгүй хуваарилалт, төсвийн зарцуулалт болон бүрдүүлэлтэд тавих хяналтыг төсвийн сар, улирлын батлагдсан хуваарийн дагуу хэрэгжүүлнэ", 41.2.5-т "энэ хуулийн 37.1.8-д заасан эрхийн хүрээнд төсвийн байгууллагын зардлыг санхүүжүүлэх", "Бугат сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн 33 дугаар тогтоол"-той нийцэхгүй, хуваарилалт, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Батлагдсан төсвийн хуваарийн дагуу нэгж байгууллагуудад санхүүжилтийг олгож байх.

Гурав. Орон нутгийн орлогын төлөвлөгөөг үзэхэд ан амьтны нөөц ашигласны төлбөр 18.1 сая төгрөгөөр, малд ногдуулах албан татвар 5.3 сая төгрөгөөр, улсын тэмдэгтийн хураамж 0.4 сая төгрөгөөр, торгуулийн орлого 0.3 сая төгрөгөөр тус тус тасарсан нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.2-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөрийн санхүүжилтийг бодитой тодорхойлох"; 14.2.5-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах"; 41 дүгээр зүйлийн 41.1-т "Батлагдсан төсвийг хэрэгжүүлэх нарийвчилсан хуваарь, төсвийн дэлгэрэнгүй хуваарилалт, төсвийн зарцуулалт болон бүрдүүлэлтэд тавих хяналтыг төсвийн сар, улирлын батлагдсан хуваарийн дагуу хэрэгжүүлнэ", 41.2.5-т "энэ хуулийн 37.1.8-д заасан эрхийн хүрээнд төсвийн байгууллагын зардлыг санхүүжүүлэх;" Бугат сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн 33 дугаар тогтоолыг зөрчсөн, иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Орон нутгийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг хангуулж ажиллах.

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг тайлан хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2026 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дөрөв. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

(мянган төгрөг)

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Бугат сумын Засаг даргын нэгтгэсэн тайлан	2	241,380.0	1	178,811.9	1	62,568.1	2	178,811.9	-	-	-	-
Бугат сумын ЗДТГ	3	363,915.7	1	339,988.7	2	23,927.0	3	363,915.7	-	-	-	-
Бугат сумын ИТХ	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Бугат сумын ОНХС	3	46,716.0	-	-	3	46,716.0	3	46,716.0	-	-	-	-
Бугат сумын ХХС	3	2,562.6	-	-	3	2,562.6	3	2,562.6	-	-	-	-
Дүн	11	654,574.3	2	518,800.6	9	135,773.7	11	654,574.3	-	-	-	-

4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөг)

Байгууллагын нэр	Бүгд	Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс таггалзах	Түүвэрт	Нийт зөрчил		Үүнээс									
									Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
							Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
							Бугат сумын Засаг даргын нэгтгэсэн тайлан	1	-	1	-	-	-	5	43,219.4	-	-	2
Бугат сумын ЗДТГ	1	1	-	-	-	-	3	1,976.8	-	-	-	-	3	1,976.8	-	-	-	-
Бугат сумын ИТХ	1	-	-	-	-	1	1	-	-	-	-	1	-	-	-	-	-	-
Бугат сумын ОНХС	1	-	-	-	-	1	2	17,908.8	-	-	-	-	2	17,908.8	-	-	-	-

Бугат сумын БХНСС	1	-	-	-	-	1	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Бугат сумын ХХС	1	-	-	-	-	1	1	2,941.2	1	2,941.2	-	-	-	-	-	-	-	-
Дүн	6	1	1	-	-	4	12	66,046.2	1	2,941.2	2	24,078.4	8	39,025.6	-	-	-	-

4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

(мянган төгрөг)

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бугат сумын ХХС	2	-	-	-	2	-	-	-
Дүн	2		-	-	2	-	-	-

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо			Санал дүгнэлтийн хэлбэр				
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТТЗ		1				1		
	НИЙТ		1				1		